Хөдөө аж ахуй хөгжлийн ирээдүй ОНӨХХК нь эрхэм зорилгоо Засгийн газрын болон аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хүрээнд улс, орон нутгийн төсөв бусад эх үүсвэрээс нийлүүлэгдсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилтийг хангах, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулах, үр нөлөөг нэмэгдүүлэх, бэлчээрийн даац хомсдож, мал эрчимтэй өссөнтэй холбоотойгоор хадлан бэлтгэх, малын тэжээл үйлдвэрлэх, төрөл бүрийн үр, бордоо нийлүүлэх, худалдаалах байдлаар эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангаж, эрсдэл даах үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх, хүнсний хангамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих, үүссэн хуримтлалаар инновацад түшиглэсэн хөрөнгө оруулалт, технологийг хөгжүүлэх бизнес үйл ажиллагаа эрхлэхэд оршино" гэж тодорхойлсон байна.

Хөдөө аж ахуй хөгжлийн ирээдүй ОНӨХХК-ий дүрэмд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тусгаж, мөрдөж ажиллажээ. Үүнд:

- Жимс, жимсгэний аж ахуйг хөгжүүлэх, таримлын болон бүтээгдэхүүний нэр төрөл, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, борлуулалтыг дэмжих,
- Өвөл, зуны хүлэмжийн аж ахуйг байгуулах, таримлын нэр төрлийг олшруулах, ирээдүйтэй болон нутагшсан сортыг туршиж үйлдвэрлэлд нэвтрүүлэх,
- Хүнсний ногоо, жимс, жимсгэнийг хатаах, хөлдөөх, хуурайшуулах дэвшилтэт технологийг нутагшуулах,
- Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн үйл ажиллагааг дэмжих, тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулах,

- Хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалах, ус хэмнэлттэй зарцуулдаг, байгаль орчинд ээлтэй, усалгааны дэвшилттэй технологи нэвтрүүлэх,
- Арьс шир болон мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх,
- Өрхийн орлогыг нэмэгдүүлж, ажлын байр бий болгох, үйлчилгээний хүрээг өргөтгөх чиглэлээр хоршиж ажиллах,
- Хөдөө аж ахуйн эдэлбэр газрыг зохистой ашиглаж газар тариалан эрхлэх, ногоон тэжээл тариалах Байгальд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй хөргөлт, халаалтын технологитой стандарт бүхий зоорийн аж ахуйг байгуулах. Хүнсний нарийн ногооны үр, бордоо нийлүүлэх, борлуулах,
- Үйлдвэрлэлд шинэ дэвшилтэд технологи нэвтрүүлэх Мал сүргийн бүтэц, үүлдэр угсаа, сүргийн чанарыг сайжруулахад стандартын шаардлага хангасан хээлтүүлэгчийг ашиглаж удмын санг хамгаалахын зэрэгцээ аймгийн цөм сүргийн өсөлтөд дэмжлэг үзүүлэх,
- Гамшгийн үед хэрэгцээтэй хүнс, шатахуун, орон гэр, хамгаалалтын хувцас, өвс, тэжээлийн нөөцийг бэлтгэх, хадгалах, худалдан борлуулах,
- Аймгийн хэмжээнд оёмол болон захиалгат оёдлын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих, кластерийн бүтэц зохион байгуулалттай үйлдвэр, цех болгон хөгжүүлэх,
- Оёмол бүтээгдэхүүний тодорхой төрөл зүйл, чанар, хийцээр ялгарах орон нутгийн брэнд бүтээгдэхүүнийг бий болгох,
- Хууль тогтоомжоор хориглоогүй бизнесийн бусад үйл ажиллагаа эрхлэх.

### **3.2 Орон нутгийн өмчит ХХК-ий гадаад, дотоод орчин**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компаний тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд, орон нутгийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжийн дагуу “Орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани” хэлбэрээр ажиллах ажиллах эрх орчин бүрдсэн байна.

Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль,
- Хөдөлмөрийн тухай хууль,
- “Монгол улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоол,
- “Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам” Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/191 дүгээр тушаал,
- “Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай” Сангийн сайдын 2022 оны 120 дугаар тушаал,
- “Автомашин ашиглалтын тухай” Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоол.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын

сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөдөө аж ахуй хөгжлийн ирээдүй ОНӨХХК-ийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Хөдөө аж ахуй хөгжлийн ирээдүй ОНӨХХК-ийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/424 дүгээр тушаалаар батлагдсан "бодлогын баримт бичиг"-т өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 436,356.6 мянган төгрөгөөр буюу 10.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт (мянган төгрөгөөр)

| Үзүүлэлт                                         | Эхний<br>үлдэгдэл  | Эцсийн<br>үлдэгдэл | Өөрчлөлт           |
|--------------------------------------------------|--------------------|--------------------|--------------------|
| Б                                                | 1                  | 2                  | 3=2-1              |
| Мөнгөн хөрөнгө                                   | 25,563.3           | 42,472.1           | 16,908.8           |
| Авлага                                           | 795,919.2          | 651,906.9          | (144,012.4)        |
| Бараа материал                                   | 1,499.1            | 3,050.9            | 1,551.8            |
| Үндсэн хөрөнгө                                   | 3,314,395.4        | 3,003,590.5        | (310,804.9)        |
| <b>Нийт хөрөнгө</b>                              | <b>4,137,377.0</b> | <b>3,701,020.4</b> | <b>(436,356.6)</b> |
| Өр төлбөр                                        | 19,950.0           | 3,629.2            | 16,320.8           |
| Засгийн газрын хувь оролцоо<br>/Эздийн өмч/      | 4,117,427.0        | 3,697,391.2        | (420,035.8)        |
| <b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө<br/>өмчийн дүн</b> | <b>4,137,377.0</b> | <b>3,701,020.4</b> | <b>(436,356.6)</b> |

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна. Тухайлбал:

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл нь ХААН банкинд байршиж байгаа бөгөөд тайлант 192,810.4 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 175,901.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.
- Авлагын данс 144,012.4 мянган төгрөгөөр буурсан нь зээлийн эргэн төлөлт хугацаандаа хийгдсэн, үүссэн авлагыг бууруулах, авлагыг цуглуулах тал дээр анхаарч ажилласнаас нөлөөлсөн ба айраг хадгалах, арьс нэхий элдэх, жимс ногоо хатаагч, сүү хөргөлтийн танк, трактор, хадлангийн салаа, хонины ноос хяргах, хүлэмжийн төрлөөр 266 зээлдэгч байна.
- Бараа материалын дансны үлдэгдэл 1,551.8 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал бэлтгэсэнтэй холбоотой байна.
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 310,804.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд 298,197.9 мянган төгрөгийн элэгдэл тооцсон байна.
- Өр төлбөр дансны үлдэгдэл 3,906.8 мянган төгрөг байна.
- Орон нутгийн хувь оролцоо дансны үлдэгдэл 420,035.8 мянган төгрөгөөр буурсан байна.

### 3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

“Хөдөө аж ахуй хөгжлийн ирээдүй” ОНӨХХК-ий тайлант онд батлагдсан зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэлийн ТУЗ-өөр батлуулан ажилласан байна. Төлөвлөгөө, гүйцэтгэлийг тайланд хавсаргалаа.

Хөдөө аж ахуй-хөгжлийн ирээдүй ОНӨХХК нь 2022 оны үндсэн үйл ажиллагааны данснаас нийт 192,810.4 мянган төгрөгийн орлого орж гүйцэтгэлээр 175,901.5 мянган төгрөгийг зарцуулж оны эцсийн байдлаар дансны үлдэгдэл 42,472.1 төгрөгний үлдэгдэлтэй тайлагнажээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу компанийн үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө /техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг тооцож ажилласан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу компанийн үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө /техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, ТУЗ-аар батлуулж, биелэлтийг хангаж ажилласан.

“Хөдөө аж ахуй хөгжлийн ирээдүй” ОНӨХХК-ий ТУЗ-ын 2022 оны 01 сарын 10-ны өдрийн 01 тогтоолоор 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 244,723.0 мянган төгрөгөөр, нийт зардлыг 218744.7 мянган төгрөгөөр 25,978.3 мянган төгрөгийн ашиг/ алдагдалтай ажиллахаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 45,000.0 төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 192,810.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 175,901.5 мянган төгрөгийн зардал гарган, 18,324.8 мянган төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 244,723.0 мянган төгрөг болж төлөвлөснөөс 192,810.4 мянган төгрөг буюу 78.7 хувиар давсан/ тасарсан нь эргэн төлөлт дутуу хийгдсэнээс шалтгаалжээ.

Нийт зардлын гүйцэтгэл 218,744.7 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 175,901.5 мянган төгрөг буюу 80.4 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь төсвийн хэмнэлтийн тухай хууль гол нөлөө үзүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг/алдагдал 18,324.8 мянган төгрөг болж, 2,004.1 мянган төгрөгөөр дутуу байгаа нь аймгийн нөөцийн хадлангийн ажлаар явсан нөлөөлжээ.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д *“Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана”* гэж заасны дагуу Хөдөө аж ахуй хөгжлийн ирээдүй ОНӨХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх орон нутгийн өмчит ХХК, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн орон нутгийн өмчит ХХК-ийн үйл ажиллагааг сайжруулах холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Анхбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөдөө аж ахуй хөгжлийн ирээдүй ОНӨХХК-ийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 01/35 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны байдлын тайлан дахь үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 3,003,590.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 45,053.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 33,790.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2-15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлуудыг

санхүүжүүлээгүй байна. Мөн хуулийн 15 дугаар зүйлд заасан хэмнэлтийн бусад арга хэмжээтэй холбоотой зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны тухай хуульд заасан нийт 148 мэдээлэл байршуулахаас 13 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

*Шийдвэрлэсэн нь:* Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

##### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант хугацаанд завсрын аудит хийгдээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг 2022 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 01/31 тоот албан бичгээр ирүүлсэн.

*Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

(мянган төгрөгөөр)

| Үзүүлэлт        | Өмнөх аудитаар өгсөн |                 | Биелэлт   |                 |              |
|-----------------|----------------------|-----------------|-----------|-----------------|--------------|
|                 | Тоо                  | Дүн             | Тоо       | Дүн             | Хувь         |
| Акт             | 3                    | 908.0           | 3         | 908.0           | 100.0        |
| Албан шаардлага | 8                    | 65,525.0        | 8         | 65,525.0        | 100.0        |
| Зөвлөмж         | 3                    | 8,910.0         | 3         | 8,910.0         | 100.0        |
| <b>Нийт дүн</b> | <b>14</b>            | <b>75,343.0</b> | <b>14</b> | <b>75,343.0</b> | <b>100.0</b> |

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын гүйцэтгэх цаг хугацааны нөөц, цар хүрээ хязгаарлагдмал байсан учраас дараагийн санхүүгийн тайлангийн аудитаар бараа материал, үндсэн хөрөнгийн үлдэгдэлд бүрэн тооллогын горим сорил хэрэгжүүлэн, сонгон шалгаруулалтгүй түрээслэгчид өгсөн хөрөнгийн ашиглалт, хамгаалалт зэргийг тусгайлан авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 7,470.0 мянган төгрөгийн 2 алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 7,470.0 мянган төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

- Мөнгөн гүйлгээний тайлангийн эцсийн үлдэгдэл санхүүгийн байдлын тайлангаас 6,000.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.
- Үндсэн хөрөнгийн тайлангийн тодруулгын үлдэгдэл санхүүгийн байдлын тайлангаас 1,470.0 мянган төгрөгөөр зөрүүтэй.

Аудитаар нийт 5,366,178.5 мянган төгрөгийн 9 зөрчил<sup>2</sup> илэрснээс 4,326,795.3 мянган төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх 6 албан шаардлага хүргүүлж, 1,039,383.2 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

#### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

#### 5.2 Албан шаардлага

1.Бараа материалын тодруулга тайлангийн дансны үлдэгдлийг жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын бүртгэлтэй тулган баталгаажуулахад бараа материалын тооллого хийж, тооцоо бодсон актаар үлдэгдлийг баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1-д *"жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө" эд хөрөнгийн тооллогыг заавал хийнэ*, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.2-д *"түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа хийнэ"* заалтыг нийцээгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам-ын 4.2.1.10-д *"аудитаар илэрсэн алдаа зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй"* заалтыг үндэслэн зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах албан шаардлага хүргүүлээ.

2. Айраг хадгалах, арьс нэхий элдэх, жимс ногоо хатаагч, сүү хөргөлтийн танк, трактор, хадлангийн салаа, хонины ноос хяргах, хүлэмжийн төрлөөр 266 зээлдэгчтэй, үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д *"дансны*

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” заалтыг нийцээгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам-ын 4.2.1.10-д "аудитаар илэрсэн алдаа зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй" заалтыг үндэслэн зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах албан шаардлага хүргүүлээ.

3. Байгууллагын даргын 2022 оны А/18 дугаар тушаалаар томилогдсон жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын комисс нь хөрөнгийн бүртгэлийн жагсаалтыг гаргаагүй, тооцоо бодсон актаар үлдэгдлийг баталгаажуулаагүй. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 4.4-д "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" заасантай нийцэхгүй, орхин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам-ын 4.2.1.10-д "аудитаар илэрсэн алдаа зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй" заалтыг үндэслэн зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах албан шаардлага хүргүүлээ.

4. "Трактор, өвс хадах тоног төхөөрөмж", "хонь хяргах машин, зөөврийн хашаа дагалдах тоног төхөөрөмж", "хонины ноос хяргах тоног төхөөрөмж", "жимс хүнсний ногоо хатаах тоног төхөөрөмж", "сүүний хөргөлтийн танк, дагалдах тоног төхөөрөмж", арьс нэхий элдэх тоног төхөөрөмж", "50 толгой хээлтүүлэгч мал тэжээх хашаа байр" зэрэг хөрөнгийг түрээсээр ашиглуулахдаа гэрээнд хууль тогтоомж зөрчсөн заалт оруулж гэрээний хугацаа дууссаны дараа үлдэх өртөгтэй хөрөнгийг гэрээ дууссаны дараа түрээслэгчид өгөхөөр тусгасан байна.

Энэ нь ТБОНӨТХ-ийн 77 дугаар зүйлийн 77.3-д "Орон нутгийн өмчид хамаарах үндсэн хөрөнгийг бусдын өмчлөлд шилжүүлэх, барьцаалах, шинээр олж авах асуудлыг гагцхүү иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний хуралдааны чөлөөт цагт Хурлын Тэргүүлэгчид шийдвэрлэнэ", ТБОНӨТХ-ийн 77 дугаар зүйлийн 77.3-д "Орон нутгийн өмчид хамаарах үндсэн хөрөнгийг бусдын өмчлөлд шилжүүлэх, барьцаалах, шинээр олж авах асуудлыг гагцхүү иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний хуралдааны чөлөөт цагт Хурлын дарга шийдвэрлэнэ" гэсэн заалтыг зөрчиж байна.

*Шийдвэрлэсэн нь:* Хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал үүссэн гэж үзсэн тул албан шаардлага хүргүүлээ.

5. Түрээсэлсэн бух, хуц, ухнаас түрээсийн төлбөрт 2022 онд аваагүй дутуу 120 толгой төлгөн хуц, 50 толгой хурган хуц, 50 толгой борлон хуц, 37 толгой шүдлэн бух орлогод авч бүртгэлд тайлагнаагүй байна. Энэ нь ТӨБЗГ-ын 2018 оны 86 дугаар

тогтоолоор баталсан "Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам"-ыг хэрэгжүүлээгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Зах зээлийн үнэ ханшаар орлогод хүлээж авхуулахаар албан шаардлага хүргүүлээ.

6. 2022 онд шилэн дансны 13 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.3, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20.5 дахь заалтыг зөрчиж байна.

*Шийдвэрлэсэн нь:* Өмнөх онд зөрчлийг арилгаж, алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх албан шаардлагыг биелүүлээгүй тул сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлагыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлээ.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримттай холбоотой асуудал**

*Илрүүлэлт:* Байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж батлаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэсэн заалтыг зөрчиж байна.

*Өгсөн зөвлөмж:* Байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах.

#### **2. Зардлын данстай холбоотой асуудал**

*Илрүүлэлт:* Түрээсийн эцэг малаас авах түрээсийн төлбөрт авсан 37 бярууг зах зээлийн үнэлгээнээс доогуур үнээр орлогдож, эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авалгүй зах зээлийн үнээс бага 350.0 мянган төгрөгөөр үнээр худалдан борлуулсан байна. Энэ нь ТБОНӨТХ-ийн 72 дугаар зүйлийн 72.2/-д "тоолсон эд хөрөнгийн үнийг бэлтгэн нийлүүлэгчийн дагалдах баримт, тухайн үеийн зах зээлийн үнийн жишигтэй тулган шалгаж, тооллогын бүртгэлд бичих", 72.5/-д "эвдэрсэн, гэмтсэн, чанар байдлаа алдсанаас хэрэгцээнд тохирохгүй болсон тухайн үеийн зах зээлийн үнийн жишгээс хэт өндөр үнээр авсан, хэт доогуур үнээр борлуулсан үндсэн хөрөнгө, түүхий эд, бараа материалын үнэ бүхий зүйлийн жагсаалтыг илрүүлж гэм буруутай хүмүүсээр төлүүлэх буюу данснаас хасуулах тухай саналаа тавих" заалттай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Алдаа зөрчлийг арилгаж, гэрээний заалтыг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн хүрээнд шинэчлэн, алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх.

#### **3. Нийт зардалтай холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Ланд круизер 100 маркийн жийп авто машиныг 2021 онд худалдан авалт хийсэн боловч техникийн тодорхойлолтод заасан шаардлагад нийцээгүй автомашин авснаас шалтгаалж норм, норматив зөрчиж сэлбэг худалдан авсан байна. Энэ нь Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах.

#### 4. Эзэмшигчийн өмчийн данстай холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Эзэмшигчдийн өмч дансны үлдэгдэл, улсын бүртгэлийн гэрчилгээний дүрмийн сангийн үлдэгдэл зөрүүтэй байна. Энэ нь Хууль зүй дотоод хэргийн сайдын 2018 оны А/208 дугаар тушаалаар батлагдсан "Хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрын улсын бүртгэл хөтлөх журам-ын 8.2-т "Хуулийн этгээдийн дараах мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг хуульд өөрөөр заагаагүй бол ажлын 15 өдрийн дотор улсын бүртгэлд бүртгүүлнэ", 8.2.3-т "хувь нийлүүлсэн хөрөнгө" гэсэн заалтыг зөрчиж байна.

**Өгсөн зөвлөмж:** Хууль зүй дотоод хэргийн сайдын 2018 оны А/208 дугаар тушаалаар батлагдсан "Хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрын улсын бүртгэл хөтлөх журам-ын 8.2 дахь заалтыг хэрэгжүүлэн, эзэмшигчийн өмчид өөрчлөлт орсон тухай бүрд Улсын бүртгэлийн хэлтэст өөрчлөлтийг хийлгэж хэвших.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа |        | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан |     | Буруу тусган илэрхийлсэн |        | Үүнээс     |        |              |  | Зөвлөмж |     |
|-------------------|------------|--------|-----------------------------------|-----|--------------------------|--------|------------|--------|--------------|--|---------|-----|
|                   | Тоо        | Дүн    | Тоо                               | Дүн | Тоо                      | Дүн    | Залруулсан |        | Залруулаагүй |  | Тоо     | Дүн |
|                   | 2          | 7470,0 |                                   |     | 2                        | 7470,0 | 2          | 7470,0 |              |  |         |     |
|                   |            |        |                                   |     |                          |        |            |        |              |  |         |     |
| Дүн               | 2          | 7470,0 |                                   |     | 2                        | 7470,0 | 2          | 7470,0 |              |  |         |     |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | Үүнээс        |                 |         |                      |                 |
|--------------------|-------------|---------------|-----------------|---------|----------------------|-----------------|
|                    |             | Төлбөрийн акт | Албан шаардлага | Зөвлөмж | Хариуцлага тооцуулах | Хууль, хяналтын |

|     |     |        |     |     |     |        |     |        | албан<br>шаардлага |                            | байгууллагад<br>шилжүүлсэн<br>асуудал |     |
|-----|-----|--------|-----|-----|-----|--------|-----|--------|--------------------|----------------------------|---------------------------------------|-----|
|     | Тоо | Дүн    | Тоо | Дүн | Тоо | Дүн    | Тоо | Дүн    | Тоо                | Албан<br>тушаал<br>тны тоо | Тоо                                   | Дүн |
|     | 9   | 5366,1 |     |     | 5   | 4326,2 | 4   | 1039,9 |                    |                            |                                       |     |
|     |     |        |     |     |     |        |     |        |                    |                            |                                       |     |
| Дүн | 9   | 5366,1 |     |     | 5   | 4326,2 | 4   | 1039,9 |                    |                            |                                       |     |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч<br>утга                                    | Нийт зөрчил |     | Үүнээс        |     |                 |     |         |     |
|----------------------------------------------------------|-------------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|-----|
|                                                          |             |     | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |     | Зөвлөмж |     |
|                                                          | Тоо         | Дүн | Тоо           | Дүн | Тоо             | Дүн | Тоо     | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил |             |     |               |     |                 |     |         |     |
|                                                          | 1           | -   |               |     | 1               | -   |         |     |
| Дүн                                                      |             |     |               |     |                 |     |         |     |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил                 |             |     |               |     |                 |     |         |     |
|                                                          |             |     |               |     |                 |     |         |     |
| Дүн                                                      |             |     |               |     |                 |     |         |     |
| Нийт дүн                                                 |             |     |               |     |                 |     |         |     |